



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/114

Хэрлэн сум

Хичээлийн жилийн 3 дугаар улирлын амралтын хугацааг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны "Хичээлийн жилийн бүтэц батлах тухай" А/85 дугаар тушаалын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хаваржилтын нөхцөл байдалтай холбогдуулан /Мал төллөх үеийн нөхцөл байдлыг харгалзан үзэж/ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн 3 дугаар улирлын амралтын хугацааг 3 дугаар сарын 27-ны өдрөөс 4 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл болгон өөрчилсүгэй.

2. Гарсан шийдвэрийн дагуу хичээлийн хуваарьт зохицуулалт хийн, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 551